

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Өмнөговь аймаг
Даланзадгад хот
2026 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас:70533539 Цахим хаяг:usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК Захирал:
Г.Энхмаа
Утас: 77450279 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	9
3.2 Албан шаардлага	9
3.3 Зөвлөмж	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	10

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ЦДШ	Цахилгаан дамжуулах шугам
ДҮТ	Диспетчерийн үндэсний төв
БНХАУ	Бүгд найрамдах Хятад Ард Улс
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16

№ 321

танай _____ -ны № _____ -г

"ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-НЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Т.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дугаар тогтоолоор Төрийн өмчит компаниудыг удирдлага, менежментээр хангах үүрэг бүхий "Эрчист Монгол" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийг байгуулагдаж компанийн 34%-ийг эзэмших болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд 92,782.1 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, 829.3 сая төгрөгийн бусад орлого бүрдүүлж, 86,759.1 сая төгрөгийн үйлдвэрлэлийн өртөг тооцож, 4,150.8 сая төгрөгийн ерөнхий удирдлагын зардал гаргаж, 2,225.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

4626050496

Бусад асуудлын хэсэг

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
2	Эргэлтийн хөрөнгө	2,219,163,673.63	2,997,515,743.40
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	80,266,382.28	305,026,535.52
4	Дансны авлага	932,296,711.25	895,827,972.49
5	Татвар,НДШ-ийн авлага	1,016,841,686.02	1,460,197,075.36
6	Бараа материал	136,809,757.68	331,090,244.07
7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	841,454.62	5,373,915.96
8	Бусад эргэлтийн хөрөнгө	52,107,681.78	
9	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,219,163,673.63	2,997,515,743.40
10	Эргэлтийн бус хөрөнгө	16,308,505,747.99	17,643,334,865.77
11	Үндсэн хөрөнгө	15,421,680,254.85	16,741,968,613.41
12	Биет бус хөрөнгө	886,825,493.14	901,366,252.36
13	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,308,505,747.99	17,643,334,865.77
14	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	18,527,669,421.62	20,640,850,609.17
15	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
16	Өр төлбөр	2,428,672,163.55	730,505,155.20
17	Богино хугацаат өр төлбөр	2,132,272,163.55	473,625,155.20
18	Дансны өглөг	1,970,564,791.09	210,780,766.49
19	НДШ-ийн өглөг	46,367.38	
20	Урьдчилж орсон орлого	125,848,750.08	224,496,938.71
21	Бусад богино хугацаат өр төлбөр	35,812,255.00	38,347,450.00
22	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,132,272,163.55	473,625,155.20
23	Урт хугацаат өр төлбөр		
24	Урт хугацаат өр төлбөр		
25	Урт хугацаат зээл	296,400,000.00	256,880,000.00
26	Урт хугацаат өр төлбөрийн дүн	296,400,000.00	256,880,000.00
27	Өр төлбөрийн нийт дүн	2,428,672,163.55	730,505,155.20
28	Эздийн өмч	16,098,997,258.06	19,910,345,453.97
29	Өмч: - төрийн	17,141,059,974.16	17,141,059,974.16
30	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	915,663,485.25	2,501,091,668.49
31	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	681,771,461.65	681,771,461.65
32	Хуримтлагдсан ашиг(алдагдал)	(2,639,497,663.00)	(413,577,650.33)
33	Эздийн өмчийн дүн	16,098,997,258.06	19,910,345,453.97
34	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,527,669,421.61	20,640,850,609.17

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	68,050,115,626.84	92,782,087,076.04
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	67,552,115,976.56	86,759,165,621.49
3	Нийт ашиг/алдагдал/	497,999,650.28	6,022,921,454.55
4	Хүүний орлого	29,369,801.13	52,424,968.86
5	Бусад орлого	742,527,221.53	776,898,732.94
6	Борлуулалт, маркетингийн зардал	30,669,045.45	28,368,590.90
7	Ерөнхий ба удирдлагын зардал	3,065,574,885.94	4,122,402,584.71
8	Санхүүгийн зардал		2,865,200.00
9	Бусад зардал	238,670,819.74	222,912,194.38
10	Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал/	(2,065,018,078.19)	2,475,696,586.36

11	Орлогын албан татварын зардал	2,936,980.11	249,776,573.64
12	Татварын дараах ашиг алдагдал	(2,067,955,058.30)	2,225,920,012.72
13	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг/ алдагдал/		
14	Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/	(2,067,955,058.30)	2,225,920,012.72

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	17,141,059,974.16	681,771,461.65	899,663,485.25	(444,213,953.44)	18,278,280,967.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				0.01	0.01
3	Өмчид гарсан өөрчлөлт			16,000,000.00		16,000,000.00
4	Зарласан ноогдол ашиг				(127,328,651.27)	(127,328,651.27)
5	Тайлант үеийн үр дүн				(2,067,955,058.30)	(2,067,955,058.30)
6	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,141,059,974.16	681,771,461.65	915,663,485.25	(2,639,497,663.00)	16,098,997,258.06
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(0.05)	(0.05)
8	Залруулсан үлдэгдэл	17,141,059,974.16	681,771,461.65	915,663,485.25	(2,639,497,663.05)	16,098,997,258.01
9	Өмчид гарсан өөрчлөлт			1,585,428,183.24		1,585,428,183.24
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,225,920,012.72	2,225,920,012.72
11	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
12	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	17,141,059,974.16	681,771,461.65	2,501,091,668.49	(413,577,650.33)	19,910,345,453.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>69,763,892,871.56</u>	<u>94,375,723,387.60</u>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	67,856,920,045.03	88,557,343,532.70
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	245,454.55	24,031,650.00
1.1.3	Буцаан авсан албан татвар		11,880.00
1.1.4	Татаас санхүүжилтийн орлого	972,083,600.00	3,416,464,800.00
1.1.5	Бусад мөнгөн орлого	934,643,771.98	2,377,871,524.90
1.2	Мөнгөн зарлагын дүн	<u>69,095,156,028.14</u>	<u>93,498,928,168.22</u>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,379,650,869.50	3,820,082,233.39
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	987,002,837.65	1,105,270,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	59,793,830,806.78	83,361,271,518.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,750,723.62	32,244,990.70
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,563,436,037.64	86,734,535.47
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	3,260,400.00	2,865,200.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,808,409,329.97	3,048,969,199.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	14,342,784.00	18,999,240.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,540,472,238.98	2,022,491,251.16
1.3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>668,736,843.42</u>	<u>876,795,219.38</u>
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
2.1	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	<u>29,644,756.83</u>	<u>52,424,968.86</u>
2.1.1	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	274,955.70	
2.1.2	Хүлээн авсан хүүний орлого	29,369,801.13	52,424,968.86
2.2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>474,753,852.50</u>	<u>664,940,035.00</u>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	424,753,852.50	629,070,035.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	50,000,000.00	35,870,000.00
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(445,109,095.67)</u>	<u>(612,515,066.14)</u>
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-</u>	<u>-</u>
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	<u>166,848,651.27</u>	<u>39,520,000.00</u>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	39,520,000.00	39,520,000.00
3.2.2	Төлсөн ногдол ашиг	127,328,651.27	
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(166,848,651.27)</u>	<u>(39,520,000.00)</u>
4	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>56,779,096.48</u>	<u>224,760,153.24</u>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>23,487,285.80</u>	<u>80,266,382.28</u>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>80,266,382.28</u>	<u>305,026,535.52</u>

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он		Зөрүү	Харьцуулалт /хувь/	
					Төлөв лөгөө	Гүйцэтгэл		Өмнөх оны мөн үетэй	Төлөв лөгөөтэй
1	Худалдаж авах ЦЭХ		сая кВт.ц	275.1	307.3	305.8	(1.5)	111.1	99.5
	Түгээлтийн алдагдал	хувиар	хувь	8.19%	9.11%	7.71%	-1.4%	94.2	0.0
		биетээр	сая кВт.ц		22.5	28.0	23.6	(4.4)	104.7
Борлуулах ЦЭХ		сая кВт.ц	252.6	279.3	282.2	2.9	111.7	101.0	
2	Нийт орлого		сая төг	68,822.0	91,503.0	93,611.4	2,108.4	136.0	102.3
	Үүнээс:	Цахилгаан эрчим хүчний	сая төг	62,205.8	82,812.6	84,238.5	1,425.8	135.4	101.7
		Түгээх үйл ажиллагааны	сая төг	5,844.3	8,185.4	8,543.6	358.2	146.2	104.4
		Үйл ажиллагааны бус	сая төг	771.9	505.0	829.3	324.3	107.4	164.2
3	Нийт зардал		сая төг	70,887.0	91,321.4	91,135.7	(185.6)	128.6	99.8
	Үндсэн үйл ажиллагааны зардал		сая төг	70,683.1	91,086.8	90,975.8	(111.1)	128.7	99.9
	Үүнээс:	Элэгдэл	сая төг	1,047.7	1,045.9	1,051.3	5.4	100.3	100.5
		Бусад тогтмол	сая төг	6,602.9	8,618.4	7,607.8	(1,010.7)	115.2	88.3
	Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг		сая төг	63,032.5	81,422.5	82,316.7	894.2	130.6	101.1
Үйл ажиллагааны бус зардал		сая төг	204.0	234.5	159.9	(74.6)	78.4	68.2	
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	(2,065.0)	181.7	2,475.7	2,294.0	(119.9)	1,362.8
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая төг	(2,068.0)	163.5	2,225.9	2,062.4	(107.6)	1,361.4
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төгрөг	1.03	1.00	0.97	(0.03)	94.5	97.5
7	Нийт авлага		сая төг	1,949.1	2,293.5	2,356.0	62.5	120.9	102.7
	Үүнээс:	ЭХ-ний	сая төг	632.3	1,300.0	601.0	(699.0)	95.0	46.2
		Бусад	сая төг	1,316.8	-	1,755.1	1,755.1	133.3	-
8	Нийт өглөг		сая төг	2,428.7	465.5	730.5	265.0	30.1	156.9
	Үүнээс:	Богино хугацаат өр	сая төг	2,132.3	208.6	473.6	265.0	22.2	227.0
		Урт хугацаат өр төлбөр	сая төг	296.4	256.9	256.9	(0.0)	86.7	100.0
9	Нийт ажиллагсад		тоо	96	109	93	(16.0)	96.9	85.3
10	Нийт цалингийн сан		сая төг	3,937.2	5,121.7	4,418.0	(703.6)	112.2	86.3
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа Исайди		цаг	41.7	65.5	41.9	(23.6)	100.6	64.0
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая төг	743.5	1,068.5	1,007.0	(61.5)	135.4	94.2

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс зөрчил арилгах 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 706.9 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

3.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага тогтоогдоогүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Үүнд:

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тайлант онд байгууллагын даргын тушаалаар спортын тэмцээний зардалд 1.7 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "*байгууллагын төсвөөр ...спортын уралдаан тэмцээн зохион байгуулах*" гэсэн хориглох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Илрүүлэлт 2: Тус байгууллага ЕСМ ХХК-ийн борлуулалтын, Апекс софт ХХК-ийн санхүүгийн программаар нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байгаа нь хоорондоо уялдаа муутай журналууд дутуу татагдаж ирэх, санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй биш дамжуулж мэдээллээ авах зэрэг бэрхшээлтэй байна. Сангийн яамны зөвшөөрөлтэй санхүүгийн программын жагсаалтад Апекс софт ХХК-ийн программ байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.11. *Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийг нийтэд мэдээлэх* гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн яамны зөвшөөрөлтэй санхүүгийн программ хангамжаар нягтлан бодох бүртгэлийг хөтлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 4,116.6 сая төгрөгийн 10 гүйлгээг мэдээлээгүй.	1	4,116.6			1	4,116.6		
Нийт дүн	1	4,116.6			1	4,116.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаалаар спортын тэмцээний зардалд 1.7 сая төгрөг зарцуулсан байна	1	1.7					1	1.7				
Тус байгууллага ЕСМ ХХК-ийн борлуулалтын, Апекс софт ХХК-ийн санхүүгийн программаар нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байгаа нь хоорондоо уялдаа муутай журналууд дутуу татагдаж ирэх, санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй биш дамжуулж мэдээллээ авах зэрэг бэрхшээлтэй байна. Сангийн яамны зөвшөөрөлтэй санхүүгийн программын жагсаалтад Апекс софт ХХК-ийн программ байхгүй байна.	1						1					
Дүн	2	1.7					2	1.7				